



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/24/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

Мөрөн сум

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитор: Г.Мөнхбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Төлбөрийн акт .....	15
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.09.25 № 01/191  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЯНЗҮРХ СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Л.ПҮРЭВДОРЖ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
1720090001-2-9670605

А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/төгрөг/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>57,876,478.28</b>	<b>191,875,698.86</b>	
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>00.00</b>	<b>609,740.59</b>	
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>00.00</b>	<b>609,740.59</b>	
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>00.00</b>	<b>609,740.59</b>	
31211	Төрийн сангийн харилцах	00.00	609,740.59	
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>00.00</b>	<b>60,478,900.00</b>	
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	60,478,900.00	
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>3,500,000.00</b>	<b>00.00</b>	
34600	Урьдчилж гарсан зардал	3,500,000.00	00.00	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>54,376,478.28</b>	<b>130,787,058.27</b>	
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>14,913,912.28</b>	<b>76,537,330.27</b>	
35110	Тусгай зориулалттай материал	1,296,383.45	15,763,240.45	
35130	Эм боох материал	13,617,528.83	60,774,089.82	
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>39,462,566.00</b>	<b>54,249,728.00</b>	
35410	Бичиг хэргийн материал	883,630.00	793,630.00	
35420	Аж ахуйн материал	23,215,206.00	25,988,734.00	
35440	Түлш, шатах тослох материал	9,110,000.00	18,693,864.00	
35460	Хүнсний материал	6,253,730.00	8,773,500.00	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>550,537,779.73</b>	<b>576,740,873.83</b>	
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>550,537,779.73</b>	<b>576,740,873.83</b>	
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>518,513,779.73</b>	<b>558,781,873.83</b>	
39201	Барилга, байгууламж, орон сууц	445,609,646.60	445,609,646.60	
39202	Хуримтлагдсан элэгдэл	-33,830,325.39	-51,584,377.23	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,200,000.00	45,760,000.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,912,777.89	-14,803,888.93	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	133,456,802.00	169,683,549.96	
39206	Хуримтлагдсан элэгдэл	-62,962,811.87	-40,030,826.06	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,455,000.00	13,626,740.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,501,753.72	-9,478,970.51	
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>32,024,000.00</b>	<b>17,959,000.00</b>	
39301	Программ хангамж	15,825,000.00	935,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	00.00	
39303	Бусад биет бус хөрөнгө	17,024,000.00	17,024,000.00	
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>608,414,258.01</b>	<b>768,616,572.69</b>	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>608,414,258.01</b>	<b>768,616,572.69</b>	
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>608,414,258.01</b>	<b>768,616,572.69</b>	
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	616,619,632.00	616,619,632.00	
51101	Өмч: - төрийн	616,619,632.00	616,619,632.00	
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-181,552,176.00</b>	<b>-21,349,861.32</b>	
51210	Өмнөх үеийн үр дүн	-181,552,176.00	-181,552,176.00	
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	160,202,314.68	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	173,346,802.01	173,346,802.01	
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>608,414,258.01</b>	<b>768,616,572.69</b>	

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/төгрөг/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>629,865,797.46</b>	<b>1,034,791,070.05</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>134,662,822.46</b>	<b>309,548,190.05</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>131,581,672.66</b>	<b>304,148,639.89</b>	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	131,581,672.66	304,148,639.89	

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	131,581,672.66	304,148,639.89
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>3,081,149.80</b>	<b>5,399,550.16</b>
122001	Хандив тусламж /дотоод/	3,081,149.80	5,399,550.16
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>88,915,275.00</b>	<b>305,210,880.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	406,287,700.00	420,032,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,426,375.00</b>	<b>237,882,890.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	6,373,450.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,926,375.00	35,128,040.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	6,751,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>189,630,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,961,000.00	33,461,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	37,961,000.00	33,461,000.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	40,527,900.00	33,866,990.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	40,527,900.00	33,866,990.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>563,213,962.17</b>	<b>859,588,755.37</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>563,213,962.17</b>	<b>859,588,755.37</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>563,213,962.17</b>	<b>826,188,755.37</b>
210101	Үндсэн цалин	310,549,475.00	356,151,325.74
210102	Нэмэгдэл	273,522,049.28	246,815,699.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,011,425.72	49,849,159.00
210104	Урамшуулал	6,336,000.00	6,960,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,680,000.00	23,526,467.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	29,000,000.00
210201	Тэтгэврийн даатгал	41,218,500.00	47,284,264.67
210202	Тэтгэмжийн даатгал	28,805,700.00	32,863,408.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,103,200.00	3,574,740.56
210204	Ажилгүйдлийн даатгал	2,482,600.00	2,926,782.20
210205	Эрүүл мэндийн даатгал	620,600.00	719,320.66
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	6,206,400.00	7,200,012.79
210301	Гэрэл, цахилгаан	31,601,140.00	18,255,136.00
210302	Түлш, халаалт	4,502,805.00	6,899,499.00
210303	Цэвэр, бохир ус	24,615,140.00	10,780,136.00
210304	Байрны түрээс	2,483,195.00	575,501.00
210401	Бичиг хэрэг	33,970,663.00	37,109,242.00
210402	Тээвэр, шатахуун	1,969,800.00	2,350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,491,200.00	20,037,480.00
210404	Ном, хэвлэл	2,900,000.00	2,785,490.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	860,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,579,015.00	11,076,272.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	7,030,648.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,016,054.96	296,318,689.10
210502	Хоол, хүнс	48,675,774.96	283,509,459.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,340,280.00	12,809,230.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00	16,650,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,000,000.00</b>	<b>16,650,000.00</b>

210701	Гадаад албан томилолт	1,878,000.00	1,094,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,878,000.00	1,094,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,940,900.00	1,828,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	27,030,800.00	231,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	850,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	88,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	49,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,100.00	60,100.00
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	1,000,000.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,039,229.21	51,497,497.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,798,000.00	9,400,300.00
210904	Найдваргүй авлагын алдагдал	47,241,229.21	42,097,197.86
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>33,400,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	33,400,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	33,400,000.00
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>66,651,835.29</b>	<b>175,202,314.68</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,419,111.20	15,000,000.00
225002	Найдваргүй авлагын алдагдал	9,419,111.20	15,000,000.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-9,419,111.20</b>	<b>-15,000,000.00</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>599,595,632.00</b>	<b>-57,254,871.79</b>	<b>571,017,223.43</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
<b>C03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>599,595,632.00</b>	<b>-57,254,871.79</b>	<b>571,017,223.43</b>
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	8,859,500.64	8,859,500.64
<b>C08</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>616,619,632.00</b>	<b>-181,552,176.00</b>	<b>608,414,258.01</b>
<b>D01</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>616,619,632.00</b>	<b>-181,552,176.00</b>	<b>608,414,258.01</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
<b>D03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>616,619,632.00</b>	<b>-181,552,176.00</b>	<b>608,414,258.01</b>
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	160,202,314.68	160,202,314.68
<b>D09</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>616,619,632.00</b>	<b>-21,349,861.32</b>	<b>768,616,572.69</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>495,202,975.00</b>	<b>664,763,980.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>495,202,975.00</b>	<b>664,763,980.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	406,287,700.00	420,032,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,426,375.00</b>	<b>177,403,990.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	6,373,450.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,926,375.00	35,128,040.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	6,751,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>129,151,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,961,000.00	33,461,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	37,961,000.00	33,461,000.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	40,527,900.00	33,866,990.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	40,527,900.00	33,866,990.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>494,202,975.00</b>	<b>659,675,239.41</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>494,202,975.00</b>	<b>659,675,239.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>494,202,975.00</b>	<b>626,275,239.41</b>
210101	Үндсэн цалин	310,549,475.00	356,151,325.74
210102	Нэмэгдэл	273,522,049.28	246,815,699.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,011,425.72	49,849,159.00
210104	Урамшуулал	6,336,000.00	6,960,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,680,000.00	23,526,467.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	29,000,000.00
210201	Тэтгэврийн даатгал	41,218,500.00	47,284,264.67
210202	Тэтгэмжийн даатгал	28,805,700.00	32,863,408.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,103,200.00	3,574,740.56
210204	Ажилгүйдлийн даатгал	2,482,600.00	2,926,782.20
210205	Эрүүл мэндийн даатгал	620,600.00	719,320.66
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	6,206,400.00	7,200,012.79
210301	Гэрэл, цахилгаан	29,961,000.00	26,961,000.00
210302	Түлш, халаалт	4,502,805.00	6,899,499.00
210303	Цэвэр, бохир ус	22,975,000.00	19,486,000.00
210304	Байрны түрээс	2,483,195.00	575,501.00
210401	Бичиг хэрэг	27,903,700.00	39,295,470.00
210402	Тээвэр, шатахуун	2,512,500.00	2,260,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,491,200.00	20,037,480.00
210404	Ном, хэвлэл	2,900,000.00	2,785,490.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,500,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,000,000.00	11,712,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,534,400.00	126,044,279.00
210502	Хоол, хүнс	24,694,100.00	109,944,279.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,840,300.00	14,100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,500,000.00	18,216,000.00
210602	Тавилга	3,500,000.00	566,000.00
210604	Урсгал засвар	00.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,000,000.00</b>	<b>16,650,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	1,878,000.00	1,094,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,878,000.00	1,094,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,940,900.00	1,828,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	27,030,800.00	231,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	850,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	88,000.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	49,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,100.00	60,100.00
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	1,000,000.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,717,000.00	9,400,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,717,000.00	9,400,300.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>33,400,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	33,400,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	33,400,000.00
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>1,000,000.00</b>	<b>5,088,740.59</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,000,000.00</b>	<b>4,479,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,000,000.00</b>	<b>4,479,000.00</b>
220001	Барилга байгууламж	1,000,000.00	4,479,000.00
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	<b>1,000,000.00</b>	<b>4,479,000.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-1,000,000.00</b>	<b>-4,479,000.00</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>609,740.59</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	493,776,600.0	486,750,249.4	7,026,350.6	98.6
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	493,776,600.0	486,750,249.4	7,026,350.6	98.6
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	493,776,600.0	486,750,249.4	7,026,350.6	98.6
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	333,655,800.0	333,655,799.7	00.3	100.0
210101	Үндсэн цалин	247,015,700.0	246,815,699.7	200,000.3	99.9
210102	Нэмэгдэл	31,200,100.0	31,200,100.0	00.0	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,960,000.0	6,960,000.0	00.0	100.0
210104	Урамшуулал	19,680,000.0	19,680,000.0	00.0	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	28,800,000.0	29,000,000.0	-200,000.0	100.7
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	45,043,600.0	44,433,859.7	609,740.3	98.6
210201	Тэтгэврийн даатгал	31,697,600.0	30,912,824.5	784,775.5	97.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,336,500.0	3,394,776.6	-58,276.6	101.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,669,300.0	2,701,826.2	-32,526.2	101.2
210204	Ажилгүйдлийн даатгал	667,400.0	674,329.7	-6,929.7	101.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,672,800.0	6,750,102.8	-77,302.8	101.2
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,961,000.0	26,961,000.0	00.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	4,560,000.0	6,899,499.0	2,339,499.0	151.3
210302	Түлш, халаалт	21,201,000.0	19,486,000.0	1,715,000.0	91.9
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.0	575,501.0	624,499.0	48.0

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,180,000.0	22,708,740.0	2,471,260.0	90.2
210401	Бичиг хэрэг	1,500,000.0	1,500,000.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	16,630,000.0	14,423,250.0	2,206,750.0	86.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,050,000.0	2,785,490.0	264,510.0	91.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	40,016,200.0	37,416,200.0	2,600,000.0	93.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,316,200.0	26,316,200.0	00.0	100.0
210502	Хоол, хүнс	11,700,000.0	9,100,000.0	2,600,000.0	77.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,545,000.0	12,545,000.0	00.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,045,000.0	5,045,000.0	00.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	6,500,000.0	6,500,000.0	00.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,022,000.0	1,022,000.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	1,022,000.0	1,022,000.0	00.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,636,000.0	1,597,600.0	38,400.0	97.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.0	400,000.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	88,000.0	88,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,400.0	49,500.0	1,900.0	96.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	36,500.0	00.0	36,500.0	00.0
210807	Газрын төлбөр	60,100.0	60,100.0	00.0	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,717,000.0	6,410,050.0	1,306,950.0	83.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,717,000.0	6,410,050.0	1,306,950.0	83.1
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	493,776,600.0	487,359,990.0	6,416,610.0	98.7
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	420,032,800.0	420,032,000.0	800.0	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	420,032,800.0	420,032,000.0	800.0	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	33,461,000.0	33,461,000.0	00.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	33,461,000.0	33,461,000.0	00.0	100.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	40,282,800.0	33,866,990.0	6,415,810.0	84.1
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	40,282,800.0	33,866,990.0	6,415,810.0	84.1
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	609,740.59	609,740.59	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	24.00	24.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0

620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	00.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>177,403,990.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>177,403,990.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>144,003,990.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>22,495,526.00</b>
210102	Нэмэгдэл	18,649,059.00
210104	Урамшуулал	3,846,467.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,850,405.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,950,584.00
210202	Тэтгэмжийн даатгал	179,964.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	224,956.00
210204	Ажилгүйдлийн даатгал	44,991.00
210205	Эрүүл мэндийн даатгал	449,910.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,586,730.00</b>
210401	Бичиг хэрэг	760,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,614,230.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,712,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>88,628,079.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83,628,079.00
210502	Хоол, хүнс	5,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,150,000.00</b>
210604	Урсгал засвар	10,150,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>72,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	72,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>231,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	231,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,990,250.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,990,250.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,400,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,400,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	33,400,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>177,403,990.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>177,403,990.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,373,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,128,040.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,751,400.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	129,151,100.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянзүрх сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн Хууль тогтоомжийн хэрэгжилт, Шилэн дансны хууль тогтоомжтой холбоотой асуудалд зөвлөмж өгч тусгасан болно.

Аудитыг Ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Баянзүрх сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тайланг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт, амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх оноосон нэрийг өөрчлөх тухай
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны өдрийн 67/А/268 дугаар тушаалаар Ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- “Хөвсгөл аймгийн засаг даргын захирамж” 2021 оны А243 түр журам батлах тухай. Ковид-19-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.
- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох “12.7” хувьд өөрчлөлт орж “11.7” хувь, Даатгуулагчийн

хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох “12.5” хувьд өөрчлөлт орж “11.5” хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянзүрх сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 859.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянзүрх сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 160.2 сая төгрөгөөр буюу 26.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг харуулав.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.6	0.6
Авлага	0	60.4	60.4
Бараа материал	54.3	130.7	76.4
Биет хөрөнгө	518.5	558.7	40.2
Биет бус хөрөнгө	32.0	17.9	-14.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>608.4</b>	<b>768.6</b>	<b>160.2</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>608.4</b>	<b>768.6</b>	<b>160.2</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0.6 сая төгрөг байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт орсон тул нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 13.5 хувь байснаас 12.5 хувь болж буурсан зөрүүтэй холбоотой байна. Мөн 2021 оны төсвийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн сангийн хэлтсээс ковид-19 цар тахлын үеийн бэлэн байдалтай холбогдуулан татан төвлөрүүлэлгүй харилцах дансанд 0.6 сая төгрөгийг үлдээж баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 76.4 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн газраас ковидын вакцин 14.4 сая төгрөгөөр, Эм боох материал 47.1 сая төгрөгөөр, аж ахуй материал 2.7 сая төгрөгөөр, түлш шатах тослох материал 9.6 сая төгрөгөөр, хүнсний материал 2.5 сая төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ.

Биет хөрөнгийн үлдэгдэл 40.2 сая төгрөгөөр өссөн нь 7.9 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, 1.3 сая төгрөгийн хөлдөөгч, угаалгын машиныг иргэний хандив байна. “Оном” сангийн хандиваар 0.4 сая төгрөгийн даралтын аппаратыг бүртгэлд тусган авсан байна. Дээд шатны төсөвт байгууллагаас 43.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, мотоциклыг, багаж хэрэгслийг эрх шилжүүлэн бүртгэлд тусгаж авсан байна. “МонПэн” төслийн хүрээнд 4.5 сая төгрөгийн тавилга, хэрэгсэл, компьютер техник хэрэгслийг орлогоор бүртгэж авсан байна. Аймгийн ИТХ-ын 2021 оны 111 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын 2021 оны 28 дугаар тогтоолоор тэг үлдэгдэлтэй 25.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэлж орлого болгосон байна.

Биет бус хөрөнгө нь 14.0 сая төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын 118 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын 28 дугаар тогтоолоор 15.0 сая төгрөгийн өртөгтэй “Цахим эрүүл мэнд” программыг акталсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 715.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 715.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвөөс 420.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 33.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 40.2 сая төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсанаас 6.4 сая төгрөгийг дутуу авсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 493.7 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Үүнд:

Гүйцэтгэлээр 420.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс 33.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 40.3 сая төгрөгийн санхүүжилтээс 33.8 сая төгрөгийн санхүүжилт авч 6.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу авч, нийт 487.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 486.7 сая төгрөгийг зарцуулж мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 0.6 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь төрийн болон орон нутгийн өмчийн бус этгээдээс авсан хандив, туламжаар 0.6 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 35.1 сая төгрөг, төсвийн

байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 6.7 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 129.1 сая төгрөгийн нийт 177.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 22.5 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 2.9 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 16.6 сая төгрөг, норматив зардалд 88.6 сая төгрөг, урсгал засварт 10.2 сая төгрөг, дотоод албан томилолтод 0.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 0.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2.9 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 33.4 сая төгрөг, нийт 177.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан байна. Ковидын тархалттай холбогдсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ихээхэн нэмэгдсэн. Ковидоор 160 хүн өвчилж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, дархлаажуулалтаар 4990 тун вакцинд иргэдийг хамруулж, нийт 189.6 сая төгрөг нэхэмжилснээс 129.2 сая төгрөгийн санхүүжилт авч 60.5 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төрийн сангийн хэлтсээс ковид-19 цар тахлын үеийн бэлэн байдалтай холбогдуулан татан төвлөрүүлэлгүй харилцах дансанд 0.6 сая төгрөгийг үлдээж баталгаажуулсан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зориулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 966.3 сая төгрөгийн 60 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 244.7 сая төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шинэ дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг Эрүүл мэндийн төв болгон өөрчилсөн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 87.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна. Аудитын зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх оноосон нэрийг өөрчилсөн эсэхийг хянах.

## 4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 301.4 сая төгрөгийн 5 алдаа илэрснээс, 56.7 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 244.7 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

- Үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй хуримталсан элэгдэлгүй 15.0 сая төгрөгийн биет бус хөрөнгийг актлах бичилтийг элэгдлийн данс хааж бичсэнийг үндсэн хөрөнгийн гарзаар бүртгэж залруулсан.
- Үнэ төлбөргүй хөрөнгө 41.7 сая төгрөгийг худалдан авснаар тайлагнасныг залруулав.
- Хандив тусламжаар авсан бараа материалын дүн болох 0.05 сая төгрөгийн үнэ төлбөргүй бичилтийг хандиваар тусламжаар тусган залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын хүн эмнэлэг хуучин нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт” оруулах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалын 8 дугаар зүйлийн 8.1-т Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг баримтална” гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт”-ийг хэрэгжүүлж ажиллах.

#### 2. Шилэн дансны хууль тогтоомжтой тухай асуудал

##### 2.1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 966.3 сая төгрөгийн 60 мэдээллээс 244.7 сая төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ, 6.2-д Энэ хуулийн 6.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна” гэж заасантай нийцэхгүй байна.

##### 2.1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. Энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6, дахь заалтуудын хуулийн хугацааг хэрэгжүүлж ажиллах, Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянзүрх сумын эрүүл мэндийн төв	5	301.4	3	56.7	-	-	-	-	2	244.7

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.